



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/458

Есөнбулаг

Сумын баяр наадмын тов тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.3 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2233 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 818 жил, Ардын хувьсгалын 103 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан Халиун сумын баяр наадмыг 2024 оны 07 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд зохион байгуулахаар тогтсугай.

2.Сумын баяр наадмыг тогтоосон хугацаанд тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан, 2024 оны төсөвтөө багтаан зохион байгуулж, хурдан морины уралдааны үеэр унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, даатгалд хамруулан стандартын шаардлагад нийцсэн хамгаалалтын хувцас хэрэгслийг бүрэн өмсүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад хяналт тавьж ажиллахыг баяр наадам зохион байгуулах комисст даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

